Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
# 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1. Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг эрхлэн явуулах, төсөв, санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, удирдах, тайлагнах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 1.1 | Улсын төсөвт орлого төвлөрүүлэх, бүртгэх, биелэлтийг тайлагнах ажлыг зохион байгуулна. | - | 291,9 тэрбум төгрөг | 2021 онд 268,9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. | 291,9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. | Улсын төсөвт 2022 онд нийт 291,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд гүйцэтгэл 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 182.8 тэрбум төгрөг буюу 62,63%-тай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.1 | Улсын төсөвт 2022 онд нийт 291,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх, бүртгэх, биелэлтийг тайлагнах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах | - | Орлогыг тухай бүр төвлөрүүлж, бүртгэсэн байдал, дүн тооцоог сар бүрийн 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ. | 2021 онд 268,9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. | Төвлөрүүлсэн орлогын дүнг сар бүр Сангийн яамтай тооцоо нийлж, акт үйлдсэн байна. | Улсын төсөвт 2022 онд нийт 291,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд гүйцэтгэл 182.8 тэрбум төгрөг буюу 62,63%-тай байна. Үүнд:<br>• Газрын тосны борлуулалтын орлого 215.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 129.6 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас БНХАУ хилээ хаасан тул 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд, 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 7 дугаар сар хүртэл БХГ-97 талбайгаас газрын тосны экспорт хийгдээгүй болно. Түүнчлэн түүхий тосны экспортыг Баянхошуу, Бичигтийн боомтоор гаргадаг байсан бол дээрх нөхцөл байдлаас хамаарч нэг чиглэлд экспорт хийж байгаа нь борлуулалт буурч, төлөвлөгөө бүрэн биелэхгүй байх үндсэн шалтгаан болсон.<br>• Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого 31.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 33.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.<br>• Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн орлого 17.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. АМГТГ нь 2022 оны Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн орлогын төсвийн саналыг 2.5 тэрбум төгрөг байхаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч манай саналаас хэт өндрөөр буюу 17.5 тэрбум төгрөгөөр баталсан. Дээрх орлогыг бүрдүүлэх боломжгүй талаар 2022.05.24-ний өдрийн 1/2862 албан бичгээр Сангийн яаманд холбогдох тайлбарыг хүргүүлсэн.<br>• Сонгон шалгаруулалтын орлого 25 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 14,5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цахимаар олгохтой холбогдуулан УУХҮ-ийн сайдын 2022.04.12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам” баталсан. Тус журамд УУХҮ-ийн сайдын 2022.10.28-ны өдрийн А/275 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлтийг оруулсан бөгөөд уг хугацаанд цахимаар сонгон шалгаруулалт зарлаагүй нь орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.<br>• Бусад орлого 2.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3.5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.<br>Сангийн сайд, УУХҮ-ийн сайдын 2013.11.14-ний өдрийн 257/236 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журмын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу 2022 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сард нийт 179.4 тэрбум төгрөгийн орлогын дүнг сар бүрийн 5-ны дотор Сангийн яамтай тооцоо нийлж, баталгаажуулсан. | |
| **Зорилго 2. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, сургалт, давтан сургалт, нээлттэй ил тод байдал, мэдээлэл сурталчилгаа, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, гамшгаас хамгаалах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 2.1 | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангана. | - | Холбогдох хууль, журам, стандартын дагуу ажиллана. | Хууль, журам, стандартыг 100% мөрдөн ажилласан. | Хууль, журам, стандартыг 100% мөрдөн ажилласан байна. | Хүний нөөцийн удирдлагаар хангах, архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол шуурхай эрхлэн явуулах зорилтын хүрээнд:<br>2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын боловсон хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 41 тушаал шийдвэр гарсан.<br>Ажилтан, албан хаагч иргэд болон бусад байгууллагаас хүний нөөцийн чиглэлээр 85 албан бичиг, 153 өргөдөл хүсэлт ирүүлснийг албан бичгээр 98, цахимаар 39, тушаалаар 54, утсаар 47 тус тус тухай бүр шийдвэрлэсэн.<br>Нийгмийн баталгааг хангах асуудлын хүрээнд буцалтгүй тусламж 14, гэр бүлийг дэмжих 3, чөлөө олгох 32, сахилгын болон сануулах 3, нийгмийн асуудал шийдвэрлэх 2, бусад 36 тушаалын төсөл боловсруулж удирдлагад танилцуулсан ба хүний нөөцтэй холбоотой нийт 131 тушаал шийдвэр гарсан. | |
| 2.1.1 | Байгууллагын боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тогтмол, шуурхай зохион байгуулах, хүний нөөцийн судалгаа хийх | - | Хуулийн хүрээнд шуурхай, алдаа дутагдалгүй ажиллана. | Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 52, шийдвэр гарсан. | /20 тушаал шийдвэр/ Судалгаа хийж санал боловсруулсан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын боловсон хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 41 тушаал шийдвэр гарсан.<br>Байгууллагын нийт албан хаагчдын судалгааг боловсрол, мэргэжил, мэргэшлээр нь гаргаж УУХҮЯ-ны мэргэжилтэн А.Пүрэвийн цахим хаягаар 1 сард хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд уг судалгааны дагуу мэдээллийг 1 болон 6 дугаар сард байршуулсан.<br>Мөн нийт албан хаагчдын төрд, улсад ажилласан жилийн судалгааг хийж, ээлжийн амралтын хоног болон цалингийн ангилал, шатлалын тооцооллыг 1 дүгээр сард гаргасан. | |
| 2.1.2. | Байгууллагын ажилтан, албан хаагчид болон бусад байгууллагаас ирсэн өргөдлийг нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд нийгмийн асуудлыг | - | Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | 53 албан бичиг, 111 өргөдөл хүсэлт шийдвэрлэсэн. | 60 тушаал шийдвэр | АМГТГ-ын даргын 2021.03.24-ний өдрийн А/44 дугаар тушаалаар Агентлагийн ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Нийгмийн баталгааг хангах асуудлын хүрээнд буцалтгүй тусламж 14, гэр бүлийг дэмжих 3, чөлөө олгох 32, сахилгын болон сануулах шийтгэл ногдуулах 3, нийгмийн асуудал шийдвэрлэх 2, бусад 36 тушаалын төсөл боловсруулж удирдлагад танилцуулсан ба хүний нөөцтэй холбоотой нийт 131 тушаал шийдвэр гарсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлүүлэн ажиллах | | | | | Ажилтан, албан хаагч иргэд болон бусад байгууллагаас хүний нөөцийн чиглэлээр 85 албан бичиг, 153 өргөдөл хүсэлт ирүүлснийг албан бичгээр 98, цахимаар 39, тушаалаар 54, утсаар 47 тус тус тухай бүр хариу хүргүүлж шийдвэрлэсэн. | |
| 2.2 | Агентлагийн үйл ажиллагаа, хуулиар хориглоогүй бүхий л мэдээллийг олон нийт, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй байлгаж, мэдээлэл авах адил тэгш боломжоор хангана. | - | Байгууллагын ил тод байдлыг 100% хангаж ажиллана. | 2021 онд ил тод байдлыг хангаж ажилласан. | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг 100% хангасан байна. | Ил тод байдлыг хангаж, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:<br>• 2022.11.20-ны өдрийн байдлаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 253.5 тэрбум төгрөгийн орлого, 262.6 тэрбум төгрөгийн зарлагын нийт 516.1 тэрбум төгрөгийн гүйлгээний мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулсан.<br>• Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр агентлагийн болон салбарын үйл ажиллагаатай холбоотой нийт 420 мэдээ, мэдээлэл гарсан.<br>• Байгууллагын цахим хуудсанд хагас жилийн байдлаар 271 мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>• Байгууллагын мэдээлэл, лавлагааны 7777-1900 дугаарын утсанд ирж буй дуудлагад тогтмол хариу мэдээлэл, лавлагаа өгч, холбогдох ажилтнуудын өрөөний болон гар утас руу дуудлагыг шилжүүлэн, мэргэжилтнүүдийн хариу өгч байгаа байдалд хяналт тавьж ажилласан. 7777-1900 утсанд давхардсан тоогоор 7000 гаруй дуудлага ирсэн.<br>• 11-11 төвд 2022.11.21-ний байдлаар иргэдээс нийт 200 гомдол, санал хүсэлт, шүүмжлэл ирүүлснээс 195-ын шийдвэрлүүлж, 5 санал, хүсэлт шийдвэрлэх шатандаа байна.<br>• Удирдах 13, гүйцэтгэх 35 албан хаагчдад "Монпас" ХХК, "Тридиум" ХХК-тай гэрээ байгуулж тоон гарын үсгийн төхөөрөмж худалдан авч Үндэсний дата төв ТӨҮГ-аар бүртгүүлж гэрчилгээ авч баталгаажуулсан. Тоон гарын үсгийг цахимаар төлөвлөгөө тайлан хянах, баталгаажуулах үйл ажиллагаанд бүрэн нэвтэрүүлсэн. | |
| 2.2.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулах | - | Хуулийн дагуу хугацаанд нь мэдээллийг байршуулна. | 92 мэдээлэл, 579.4 тэрбум төгрөгийн гүйлгээний мэдээллийг байршуулсан. | Хүний нөөцийн 12 мэдээ болон бусад мэдээллийг бүрэн байршуулсан байна. | Төсөв, санхүүтэй холбоотой тухай бүр 60, сар бүр 20, улирал бүр 3, хагас жил 4, жилдээ нэг байршуулах 4, нийт 91 мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулсан. 2022.11.20-ны өдрийн байдлаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 253.5 тэрбум төгрөгийн орлого, 262.6 тэрбум төгрөгийн зарлагын нийт 516.1 тэрбум төгрөгийн гүйлгээний мэдээллийг шилэн дансанд байршуулаад байна.<br>Байгууллагын хүний нөөцийн 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 1-10 дугаар сарын бүтэц, орон тооны мэдээллийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шилэн дансанд сар болгоны 7-ны өдрийн дотор байршуулсан. | |
| 2.2.2 | Салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв, үйл ажиллагааны үр дүнг хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах | - | Үнэн зөв, бодитой мэдээ, мэдээллийг бэлтгэн нийтлүүлнэ. | Нийт 84 мэдээ, мэдээлэл | 60 мэдээ, мэдээлэл | Ашигт малтмал, газрын тосны салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв үйл ажиллагааны үр дүнгээр хэвлэлийн 196 мэдээ бэлтгэн олон нийтэд мэдээлсэн.<br>Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдсэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон салбарын хэмжээн дэх цаг үеийн мэдээ, мэдээллийг удирдлагад тухай бүр танилцуулж, шаардлагатай тохиолдолд тэдгээрт тайлбар, тодруулга, залруулга 35-ыг бичиж хянуулах, нийтлүүлэх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>2022.11.21-ний өдрийн байдлаар олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр агентлагийн болон салбарын үйл ажиллагаатай холбоотой нийт 420 мэдээ, мэдээлэл гарсан байна. Нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг агуулгаар нь авч үзвэл олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээ, мэдээллийн 13.2%-ийг салбарын болон агентлагийн үйл ажиллагаатай холбоотой, 51%-ийг газрын тосны олборлолт, газрын тосны бүтээгдэхүүний хангамж үнэтэй холбоотой, 10.9%-ийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой, үлдсэн 27%-ийг бусад мэдээлэл эзэлж байна.<br>Дэлхийн зах зээл дээрх шатахууны үнийн өсөлтийн талаарх сурталчлан таниулах зорилго, чиглэл бүхий 20 контентыг бэлтгэн шуурхай нийтэлж, тодруулга тайлбарыг 44 удаа (100k+ like тай 10+ хуудас, 5000+ найзтай 50 гаруй профайл, мэдээ мэдээллийн сайтууд, зорилтот группт 226 мэдээний түгээлт хийж, олон нийтэд хүргэсэн.<br>11-11 төвд 2022.11.21-ний байдлаар иргэдээс нийт 200 гомдол, санал хүсэлт, шүүмжлэл ирүүлснээс 195-ын шийдвэрлүүлж, 5 санал, хүсэлт шийдвэрлэх шатандаа байна.<br>Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд хийгдэж буй геологи, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор уулзалтыг 2022.03.21-ний өдрөөс 2022.05.02-ны өдрүүдэд 18 аймагт зохион байгуулж, уулзалтын талаар 60 мэдээ бэлтгэн олон нийтэд хүргэсэн. | |
| 2.2.3 | Монгол Улсад уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг | - | Төлөвлөгөөний дагуу ажлыг хэрэгжүүлж, олон нийтийн мэдээллийн | - | Төлөвлөгөөний дагуу ажлыг хэрэгжүүлж, олон нийтийн мэдээллийн | УУХҮ-ийн сайдын 2021.12.24-ний өдрийн А/306 дугаар “Ойг тэмдэглэх тухай” тушаалаар ажлын хэсгийг байгуулсан.<br>УУХҮ-ийн сайдын 2022.01.24-ний өдрийн А/10 дугаар “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар Монгол Улсад уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | | хэрэгсэлд мэдээ мэдээллийг тухай бүр бэлтгэн нийлүүлнэ. | | хэрэгсэлд салбарын үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр бэлтгэн нийтлүүлсэн байна. | арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн удирдамж боловсруулж, ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>● Уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд 2022.03.28-29-ний өдрүүдэд Баруун-Урт хотод “Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хамтын ажиллагаа, боломж, шийдэл” Зүүн бүсийн хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан. Эрдэс баялгийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын хүрээнд орон нутгийн удирдлагууд, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжтэй хийх 18 аймгийн уулзалт, хэлэлцүүлгийг АМГТГ-аас 2022.03.21-ний өдрөөс 2022.05.02-ны өдрүүдэд зохион байгуулж орон нутгийн удирдлагууд болон аж ахуйн нэгжүүдтэй тулгамдаж буй асуудлаар санал солилцож ажилласан.<br>● 2022.09.19-23-ны өдрүүдэд болсон Монгол Улсад уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан Mongolian mining week 2022 арга хэмжээг зохион байгуулахад хамтран оролцож, салбар хурлуудад танилцуулагдсан илтгэлийг бэлтгэж, Хариуцлагатай уул уурхай ба Орон нутаг салбар хуралдааныг хариуцаж зохион байгуулж ажилласан.<br>● “Уул уурхайн салбарт мөрөө үлдээсэн 100 эрхэм” номд оруулах мэдээлэл бэлтгэж, УУХҮЯ-ны УУБГ-ын Техник, технологийн хэлтэст chtsogtbaatar@gmail.com хаягаар 2022.10.14-ний өдөр хүргүүлсэн.<br>● Уул уурхайн салбарын 100, Уул уурхайн салбарын дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 50 жилийн ой, Уурхайчдын өдөрт зориулсан Хөдөлмөрийн баатар, гавьяатуудын нэрэмжит Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг УУХҮЯ, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монголын уул уурхайн үндэсний ассоциацитай хамтран 2022.12.08-ны өдөр зохион байгуулсан. Бага хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд бага хурлын удирдамжийг батлуулж, 150 гаруй оюутнуудтай уулзалт ярилцлага хийж, хурлын зар, судалгаа хийж буй оюутнуудын сурвалжилга, дараагийн шатанд шалгарсан болон байр эзэлсэн оюутнуудын талаар мэдээлэл бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулалтыг хийсэн редакцын зөвлөл, шүүгчдийн бүрэлдэхүүнийг ажиллуулж, эмхэтгэлийг хэвлүүлсэн. | |
| 2.2.4 | Цахим хөгжлийн багц /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай/ хуулыг байгууллагын хэмжээнд сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах | - | Байгууллагын дотоод журам баримт бичигт тусгагдаж, хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | - | Хуулийг судалж бүрэн хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлсэн байна. | ХЗДХЯ-нд Газрын даргын 2022.08.31-ний өдрийн 1/4371 дугаар албан тоотыг хүргүүлж ХЗДХЯ-ны Хуулийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Амгалан, ЦХХХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Сүрэнхоролоор 2022.09.01-ний өдөр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, 2022.09.02-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн танилцуулгыг нийт албан хаагчдад зориулан зохион байгуулсан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд:<br>- Монгол улсын Ерөнхий сайдын 2022.07.04-ний өдрийн 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж АМГТГ-аас нийтэд нээлттэй байлгах хуульд заасан 5 багц 119 мэдээллийг хариуцах, хяналт тавих албан хаагчид болон мэдээллийг нийтлэх хугацааг тодорхой болгосон газрын даргын 2022.08.10-ны өдрийн Д/04 дугаар албан даалгаврыг батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажилласан.<br>-ЦХХХ-ны сайдын 2022.04.07-ны өдрийн 01/491 дугаар албан тоотын дагуу “АМГТГ-аас нээлттэй байлгах өгөгдлүүдийг тодорхойлж, 25 өгөгдлийн жагсаалтыг ЦХХХЯ-нд 2022.04.26-ны өдрийн 1/2267 албан тоотоор болон mandakh@gmail хаягаар хүргүүлсэн нь ЗГ-ын 2022.06.15-ны өдрийн 232 дугаар тогтоолоор батлагдсан.<br>-АМГТГ-ын “Нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г агентлагийн даргын 2022.10.27-ны өдрийн А/129 дугаар тушаалаар батлуулж хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна. Батлагдсан нээлттэй өгөгдлийг ЗГ-ын баталсан журмын шаардлагад нийцүүлэн шинээр үүсгэх, загвар батлуулах ажлыг газар хэлтсүүдийн холбогдох албан хаагчидтай хамтран зохион байгуулж бэлэн болсон 2 өгөгдлийг төрийн байгууллагуудын нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд /opendata.gov.mn/ 11 дүгээр сард байршуулаад байна.<br>-Нээлттэй өгөгдөл болон нээлттэй мэдээллийг байгууллагын вэб сайтад нийтлэх цэсүүдийг шинээр хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж газрын даргаар батлуулан гүйцэтгэгчийг шалгаруулах ажлыг хийж байна.<br>- Хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний цахим системийн өргөтгөл сайжруулалтын ажлын Ажлын даалгаврыг Цахим хөгжлийн багц хуулиуд, тэдгээрийг дагалдан гарсан журам, дүрэмд нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулж Агентлагийн даргаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022.10.26-ны өдөр батлуулсан. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмын дагуу ажлын даалгаврыг 2022.11.01-ний өдөр burtgel@mddc.gov.mn хаягаар ЦХХХЯ-д хүргүүлж улсын бүртгэлд бүртгүүлсэн ба үг яамнаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийг 2022.12.01-ний өдөр төслийн багт хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.<br>- Байгууллагын мэдээлэл, лавлагааны 7777-1900 дугаарын утсанд ирж буй дуудлагад тогтмол хариу мэдээлэл, лавлагаа өгч, холбогдох ажилтнуудын өрөөний болон гар утас руу дуудлагыг шилжүүлэн, мэргэжилтнүүдийн хариу өгч байгаа байдалд хяналт тавьж ажилласан. Тайлант 7777-1900 утсанд давхардсан тоогоор 7000 гаруй дуудлага ирсэн.<br>- Байгууллагын мэдээлэл, лавлагааны утаснаас тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд цаг үеийн яаралтай зар, мэдээллийн чанартай нийт 23700 мессежийг илгээсэн.<br>- ЦХХХЯ-ны 2022.09.30-ны өдрийн 03/1643, УУХҮЯ-ны 2022.10.06-ны өдрийн 10/2626 дугаар албан тоотын дагуу ЦХХХЯ болон Монголын нотариатчидын танхим хоорондын хамтран ажиллах 2022 оны С-02/2022/02 тоот санамж бичигт заасан 74 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг нотариатаар гэрчлүүлэхийг шаардахгүй байх, байгууллагын чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавар, маягтад зохих өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Агентлагийн даргын 2022.11.21-ний өдрийн А/143 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.<br>Кибер аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:<br>- Үндэсний Дата төв УҮГ-тай Агентлагийн байгуулсан Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах, цахим шуудан, домэйн нэр олгох гэрээг 2022.05.16-ны өдөр шинэчлэн байгуулж тус газарт хүргүүлсэн.<br>-Байгууллагын сервер, сүлжээний аюулгүй байдлыг хангах, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх хамгаалалтын түвшинг дээшлүүлэх" зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг хянаж, газрын даргаар батлуулсан.<br>Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:<br>- УУХҮЯ-ны 2022.05.04-ний өдрийн 03/1304, ТЕГ-ын 2022.04.27-ны өдрийн 551 албан тоотын дагуу | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд хүний биометрик мэдээллийг хуульд нийцүүлэн ашиглах заалтыг оруулж газрын даргын 2022.05.26-ны өдрийн Б/50 дугаар тушаалаар батлуулсан. Нийт албан хаагчдаас алганы хээгээр цаг бүртгүүлэх зөвшөөрлийг бичгээр авч, цуглуулсан хурууны хээний мэдээллийг устгаж 2022.05.16-ны өдрийн 1/2677 албан тоотоор Тагнуулын ерөнхий газарт тайлагнасан. | |
| 2.2.5 | Төрийн байгууллага хооронд солилцох албан бичиг, мэдээллийн урсгалыг цахимжуулж тоон гарын үсгийн хэрэглээг хэвшүүлэх | - | Бичиг хэрэг, шуудангийн зардал хэмнэгдсэн байна. | 28 албан хаагчид тоон гарын үсгийн төхөөрөмж, гэрчилгээ авч тайлан, төлөвлөгөө хянах үйл ажиллагаанд тоон гарын үсгийг туршиж байна. | Албан бичиг баталгаажуулах эрх бүхий 11 албан тушаалтанд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлсэн байна. | Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:<br>• Архивын ерөнхий газарт цахим албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт авах тухай албан бичгийг 2022.03.28-ны өдрийн 4/1671 тоотоор хүргүүлж 2022.05.31-ний өдөр байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан.<br>• 2022 онд Удирдах-13, гүйцэтгэх-36 албан хаагчдад “Монпас са” ХХК, “Тридиум э-секьюрити” ХХК-тай гэрээ байгуулж тоон гарын үсгийн төхөөрөмж худалдан авч Үндэсний дата төв ТӨҮГ-аар бүртгүүлж гэрчилгээ авч баталгаажуулсан.<br>• Хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө тайлангийн цахим системд тоон гарын үсгийн хэрэглээ бүрэн нэвтэрч 2000 орчим тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн 28 албан хаагч үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>• Албан хэрэг хөтлөлтийн Эйбл системд “Монпасс са” ХХК-ийн тоон гарын үсгийн төхөөрөмжийг тохируулж, тоон гарын ашиглах сургалтыг 2022.07.29, 2022.08.04-ний өдөр хийсэн. “Тридиум” ХХК-ийн тоон гарын үсгийн төхөөрөмжийг Эйбл системд тохируулах ажил хийгдэж байна.<br>• Уул уурхайн кадастрын компьютержсэн системд тоон гарын үсгийг нэвтрүүлэх төрийн цахим хөгжлийн бодлого шийдвэртэй уялдуулах тодорхой санал боловсруулж 2022.10.17-ны өдөр Кадастрын хэлтэст хүргүүлсэн.<br>• Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох системд тоон гарын үсгийг нэвтрүүлсэн | |
| 2.3 | Сургалт, давтан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Сургалт, давтан сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. | 2021 онд сонгон шалгаруулалт явагдаагүй. 134 албан хаагч сургалтад хамрагдсан. | Сургалтын үйл ажиллагаа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан байна. | Байгууллагын сургалтын төлөвлөгөө боловсруулан 2022.09.14-ний өдрийн А/106 дугаар тушаалаар батлуулсан.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар давтагдсан тоогоор 339 албан хаагчид сургалтад хамрагдсан.<br>Засгийн газрын 2013 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу 2022 оны сургалтын урамшууллын зарцуулалтын төлөвлөгөөг УУХҮЯ-ны Төрийн нарийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгийн даргын 2022.03.18-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар батлуулсан. Тус батлагдсан төлөвлөгөөнд сургалтын хөрөнгө хүрэлцэхгүй шалтгаанаас 2022 онд гадаадад тэтгэлэгтэй суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахгүйгээр зөвхөн өмнөх онуудад суралцаж буй "Урт хугацааны сургалтын гэрээ" байгуулсан оюутнуудын тэтгэлгийн зарцуулалтыг төлөвлөж тусгасан.<br>Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам"-ын дагуу 2022 онд гадаадад тэтгэлэгтэй суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг сургалтын хөрөнгө хүрэлцэхгүй, 2021 оны үлдэгдэлтэй байсан тул зохион байгуулахгүй байхаар шийдвэрлэсэн.<br>Жилийн эцсийн байдлаар "Урт хугацааны сургалтын гэрээ" байгуулан суралцаж буй суралцагсдын 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилийн сургалтын төлбөр болох 35 оюутны сургалтын төлбөр, тэтгэлэг шилжигдсэн.<br>Нийт суралцаж буй суралцагсдын сургалтын гэрээнд заасны дагуу хяналт тавьж, улирал бүр дүнгийн мэдээ болон төлбөрийн нэхэмжлэлийг авч удирдлагад танилцуулан ажилласан. | |
| 2.3.1 | Агентлагийн ажилтан, албан хаагчдыг богино, дунд хугацаат сургалтад жигд хамруулах ажлыг зохион байгуулах | - | Төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж батлуулах, албан хаагчдыг хамруулна. | 2021 онд 134 албан хаагч сургалтад хамрагдсан. | 1 төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж батлуулсан байна. Албан хаагчдыг төлөвлөгөөний дагуу сургалтад жигд хамруулсан байна. | Байгууллагын сургалтын төлөвлөгөө боловсруулан 2022.09.14-ний өдрийн А/106 дугаар тушаалаар батлуулсан.<br>АМГТГ-ын нийт албан хаагчдыг богино болон дунд хугацааны сургалтад жигд хамруулан ажиллав. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 339 албан хаагчид сургалтад хамрагдсан.<br>• Сангийн яамнаас зохион байгуулагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг" сэдэвт сургалт 1;<br>• "Алсын хараа 2050" сургалтад 3;<br>• Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг" сэдэвт богино хугацааны сургалт 2;<br>• Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Ашигт малтмалын хайгуулын хэлтсийн мэргэжилтэн 1;<br>• Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 2;<br>• Төрийн албан хаагчийн Хүний нөөцийг чадавхжуулах сэдэвт сургалт 1;<br>• Газрын тосны амьдралын мөчлөг сэдэвт" сургалт 5;<br>• Худалдан авах ажиллагаа А-3 сургалт 6; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Өгөгдлийн сангийн удирдлага, шинжилгээ, өгөгдлийн даамлын сургалтад 2;<br>• Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн яамнаас зохион байгуулж буй "Орд ашиглалтын гэрээ" сургалт 2;<br>• "Алсын хараа 2050" Шинэ сэргэлтийн бодлого 48 албан хаагч;<br>• Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдын мэргэшүүлэх дунд хугацааны сургалт 3;<br>• Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 1;<br>• Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3;<br>• Төрийн захиргааны удирдах түвшний албан хаагчдад зориулсан сургалтад 1;<br>• Систем сэтгэлгээ 1;<br>• Дизайн сэтгэлгээ 1;<br>• Зан үйлийн нөлөө 1;<br>• Медиа трайнер 1;<br>• Магистр, мэргэжил дээшлүүлэх сургалтад 7;<br>• "Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын соёлоо түгээх нь" сургалтад 120<br>• Архив, албан хэрэг хөтлөлт 127 албан хаагч хамруулсан.<br><br>Төлөвлөгөөний дагуу 2021 онд нийт 134 албан хаагч сургалтад хамрагдсан 2022 онд давхардсан тоогоор 339 албан хаагч сургалтад хамруулсан байна. | |
| 2.4 | Гадаад орнуудаас ирүүлсэн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | - | Үр ашигтай зохион байгуулж ажиллана. | 1 төсөл хэрэгжиж 1 төсөл хэрэгжихээр судлагдаж байна. | Хэрэгжүүлэхээр ирүүлсэн төсөл, хөтөлбөр саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. | АМГТГ-т Гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй 2 төсөл байна. Үүнд:<br>• 2022-2025 онд хэрэгжиж буй "Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ" төсөл – Төслийг хэрэгжүүлэх гэрээ БГР, УУХҮЯ, АМГТГ, ҮГА хооронд 2022 оны 6 дугаар сард байгуулагдсан. АМГТГ-ын даргын 2022.06.23-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, ажлын хэсгийн уулзалт, хурал, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, оролцох, хурлын тэмдэглэл хөтлөх, газрын даргыг мэдээллээр хангах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>• 2021-2025 онд хэрэгжиж буй "Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх" төсөл - Төслийн хүрээнд АМГТГ-т ажиллаж буй БНСУ-ын 2 мэргэжилтэнтэй хамтран төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 удаагийн чадавхижуулах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтыг зохион байгуулсан. УУГТТЛ-ийн барилгын засвар шинэчлэлийн зураг төслийг боловсруулах гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулсан.<br>Шинээр мэдүүлсэн төслийн санал:<br>• МУ-ын БШУЯ, БНХАУ-ын Шинжлэх Ухаан, Технологийн яам хооронд байгуулсан хамтарсан судалгааны хөтөлбөрийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх хамтарсан төслийн шалгаруулалт зарласан. Энэхүү шалгаруулалтад Хятадын Геологийн албаны харьяа Хөгжлийн судалгааны төвтэй хамтран “Монгол Улсын голлох ашигт малтмалын хөгжүүлэлт ба ашиглалтын төлөв байдлын үнэлгээ, технологийн аргачлалын судалгаа”-ны чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр төслийн саналыг УУХ-тэй хамтран бэлтгэж 2022.03.16-ны өдөр мэдүүлсэн боловч БШУЯ-наас дэмжигдээгүй.<br>• Австрали, Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП II) 2022-2023 онд хамтран хэрэгжүүлэх төслийн санал хүлээн авч байгаатай холбоотойгоор мэргэжлийн хэлтсүүдээс төслийн санал авч нэгтгэн 2022.04.27-ны өдрийн 1/2283 тоот албан бичгээр АМЕП төслийн багт хүргүүлсэн. | |
| 2.4.1 | Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн ажлыг нэгтгэн зохион байгуулж, бүтцийн холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах | - | Үр ашигтай зохион байгуулж ажиллана. | 3 төсөл хэрэгжиж 1 судалгааны ажил хэрэгжихээр судлагдаж байна. | Харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн 1 хэрэгжилтийг гаргана. | Хэрэгжиж буй 2 төсөл:<br>Төсөл 1: 2022-2025 онд хэрэгжиж буй “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” төсөл – Энэхүү төсөл нь АМГТГ-т 2017-2022 оны хооронд хэрэгжиж дууссан “Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь институцийн болон боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх – II” төслийн үргэлжлэл төсөл бөгөөд Монгол, Германы Засгийн газар хоорондын Техникийн туслалцааны хамтын ажиллагааны хуралдаан дээр УУХҮЯ-наас гаргасан хүсэлтийн дагуу УУХҮЯ, ҮГА-ыг оролцуулан уг төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Төслийг хэрэгжүүлэх гэрээ ХБНГУ-ын Гео Шинжлэх Ухаан Байгалийн нөөцийн хүрээлэн (БГР), УУХҮЯ, АМГТГ, ҮГА хооронд 2022 оны 6 дугаар сард байгуулагдсан. Төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн АМГТГ-ын даргын 2022.06.23-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсгийн хүрээнд дараах ажлуулыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>• УУХҮЯ, ҮГА-тай хамтран төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.<br>• Ажлын хэсгийн 2 удаагийн уулзалтыг 2022.11.11, 2022.12.05-ны өдрүүдэд зохион байгуулж, хурлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмдэглэл хөтлөн ажлын хэсгийн даргаар хянуулж төслийн нэгжид хүргүүлсэн.<br>• УУХ-тэй хамтран ГУУМС-ын ажлын даалгавар боловсруулах хэлэлцүүлгийг зохион байгуулж, ГУУМС-ын ажлын даалгаварыг боловсруулан батлуулах ажлыг гүйцэтгэсэн.<br>• Ажлыг хэрэгцээтэй байгаа мэдээллийн технологийн сервер, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж төслийн нэгжид хүсэлт гаргасан.<br>Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх” төсөл<br>Төслийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг тогтолцоог бүрдүүлэхэд бодлогын зөвлөмж өгөх, УУГТТЛ-ийн орчныг сайжруулах, шинжилгээний тоног төхөөрөмжийг шинэчлэх, мэргэжилтэн, шинжээчдийг чадавхжуулах үндсэн ажлууд хийгдэнэ. Төслийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу АМГТГ-ын удирдлагууд болон мэргэжилтэн шинжээчдийг чадавхжуулах 4 удаагийн сургалтыг БНСУ-д зохион байгуулахад сургалтад оролцогчдын нэрсийг гаргах, гадаад томилолтын тушаал батлуулах, албан пасспорт авах, удирдамж батлуулах, төлөвлөгөө гаргах зэрэг бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br>УУГТТЛ-ийн барилгын засварын ажлыг зураг төслийг гүйцэтгэх компанийн сонгон шалгаруулах худалдах авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан компанитай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.<br>Хэрэгжиж дууссан 1 төсөл: “Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь институцийн болон боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх – II” төсөл (2017-2022)<br>ТӨСЛИЙН ҮР ДҮН: Энэхүү төсөл нь 2017 оноос 2022.03.31-ны хугацаанд АМГТГ-т хэрэгжиж дууссан. Төслийн хугацаанд АМГТГ-т ашиглагдаж байгаа Уул уурхайн кадастрын компьютержсон систем /кадастрын систем/, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө тайлангийн цахим систем /e-reporting/ гэсэн 2 үндсэн цахим мэдээллийн системийг өргөтгөн сайжруулах ажлуудыг гүйцэтгэхэд УУХ, КХ-тэй хамтран ажилласан. Мөн АМГТГ-ын боловсон хүчнийг чадавхжуулах, хөгжүүлэх сургалтууд зохион байгуулах, шаардлагатай сервер, тоног төхөөрөмжүүдийг худалдан авах хэрэгцээ шаардлагыг судлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | Цар тахлын эсрэг арга хэмжээ авах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллана. | - | Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлнэ. | Холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлсэн. | Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 385 дугаар тогтоол, 2022 оны 01, 66, 67, дугаар тогтоолууд, Улсын онцгой комиссын тогтоол, тушаал шийдвэрүүдийг тус тус үндэслэн Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас үүдэн учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах, цар тахлын халдварын тархалтыг зогсоох, албан хаагчдыг ажлын тусгай горимд шилжүүлэх зорилгоор АМГТГ-ын даргын 2022 оны А/11, А/19 дүгээр тушаалуудыг тус тус гаргаж, хууль тогтоомжийн биелэлтийг бүрэн хангаж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажилласан.<br>Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны шуурхай штабын 98983046 дугаар утсанд Коронавирусийн нөхцөл байдлын мэдээг өдөр бүр бусад холбогдох мэдээ, тайланг тухай бүр өгч ажилласан. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар өгч байгаа заавар, зөвлөмжийг байгууллагын албан ёсны веб сайт, пэйж хуудсаар дамжуулж, анхааруулан ажилласан. | |
| 2.5.1 | Цар тахлын үед салбарын уурхай, үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажлыг зохион байгуулах, Уурхайн ажилчдын ээлж солилцох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж мэдээ мэдээллээр хангах | - | Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлнэ. | Холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлсэн. | Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна. | Улсын онцгой комисс, Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны шуурхай штабаас ирүүлсэн чиглэлийн дагуу цар тахлын үед уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, уурхай, үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, байгууллагын албан ёсны веб сайт, пэйж хуудсаар холбогдох мэдээ мэдээллийг тухай бүр дамжуулж ажилласан.<br>Мөн Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинд салбарын аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдсан талаарх судалгааг сар бүр 6 удаа, Батлан хамгаалах яам дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан шаардлагатай мэдээ мэдээллийг 2 удаа тус тус нэгтгэж Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны шуурхай штабын нарийн бичгийн даргын erdenetsetseg@mmhi.gov.mn мэйл хаягаар хүргүүлсэн. | |
| **Зорилго 3. Газрын тосны хайгуул, ашиглалтын өртөг нөхөгдөх зардалд хяналт тавих, газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 3.1 | Газрын тосны хайгуул, | - | Холбогдох хууль, журам, | Гэрээлэгчдийн 2021 оны 1-3 | Өртөг нөхөгдөх зардалтай | Холбогдох хууль, журам, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 14 талбайн 474.8 сая ам.долларын төсөв батлагдаж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалтын өртөг нөхөгдөх зардалд хяналт тавих, газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна. | | бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцсэн байна. | дугаар улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авсан, төлбөрийг төвлөрүүлсэн. | холбогдох төсөв, мэдээ тайланг нэгтгэж, орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | 2021 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 3 дугаар улиралд нийт 126.3 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардлын тайланг нэгтгэн, 31.6 сая ам.долларын тосны экспортын орлого болон 1.9 сая ам.долларын төлбөр, урамшууллыг төвлөрүүлсэн. Үндэсний аудитын газрын баталсан "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх" аудитын төлөвлөгөөний дагуу гэрээлэгчийн 2014-2018 онд тайлагнасан өртөг нөхөгдөх зардалд санхүүгийн шалгалт хийж, баталгаажуулах ажлын хүрээнд гэрээлэгчийн тайлант хугацаанд манай байгууллагад ирүүлсэн олборлолтын үйл ажиллагаатай холбоотой анхдагч тайлан, мэдээ, тооцоо, судалгаа зэрэг шаардлагатай мэдээллийг ажлын хэсэгт гарган өгч, холбогдох мэдээ, мэдээллээр ханган ажилласан.<br>Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниудын 2019, 2020 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын анхан шатны баримт материалд үндэслэн хянан шалгаж, дүгнэлт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг АМГТГ-ын даргын 2021.11.04-ний өдрийн А/132 дугаар тушаалаар баталсан тул анхан шатны баримт, материалд тулгуурлан шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд дүгнэлтийн төслийг 2022.10.28-ны өдрийн 1/5330 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. | |
| 3.1.1 | Гэрээлэгчдээс ирүүлсэн 2022 онд хийх ажлын төлөвлөгөө, төсвийг холбогдох хэлтсүүдтэй хамтран хэлэлцэж батлуулах, өртөг нөхөгдөх зардлын тайланг улирал бүр хүлээн авах, Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөр урамшууллыг | - | Төлөвлөгөө, төсөвт санал, дүгнэлт гарган ажилласан эсэх, батлагдсан төсөв, гэрээлэгчдийн ирүүлсэн өртөг нөхөгдөх зардлын тайлангийн нэгтгэлээр | Гэрээлэгчдийн 2021 оны 1-3 дугаар улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч, нэгтгэсэн. | Өртөг нөхөгдөх зардалтай холбогдох төсөв, мэдээ тайланг нэгтгэж, орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, төлбөр урамшууллыг төлөхгүй байгаа Гэрээлэгчдийн | АМГТГ-ын даргын 2022.01.07-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Газрын тосны хайгуулын 13 гэрээлэгч компанийн, 2022.02.22-ны өдрийн А/29 дугаар тушаалаар "Доншен газрын тос /Монгол/" ХХК-ийн, 2022.03.17-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 2021 онд хийсэн хайгуулын ажлын үр дүн, газрын тосны хэтийн төлөвийг хэлэлцэх, 2022 оны жилийн ажлын уулзалт зохион байгуулах, төлөвлөгөө, төсөв батлах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хүрээнд Газрын тосны хайгуулын хэлтэс, Газрын тосны ашиглалтын хэлтэстэй хамтран ажиллаж, санал дүгнэлт гаргасан бөгөөд 2022 оны төлөвлөгөө, төсвийг хүлээн авч бүтээгдэхүүн хуваах гэрээт ашиглалтын 3 талбайн 436.9 сая ам.доллар, хайгуулын 11 талбайн 37.8 сая ам.доллар нийт 474.7 сая ам.долларын төсөв батлагдаад байна. Газрын тосны хайгуул, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тооцож, нэхэмжлэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөр урамшууллыг төлөхгүй байгаа Гэрээлэгчдийн мэдээллийг нэгтгэн гаргаж нөхөн төлүүлэх арга хэмжээг авах | | | | мэдээллийг нэгтгэн гаргаж нөхөн төлүүлэх арга хэмжээг авсан байна. | ашиглалтын үйл ажиллагаанд 2021 оны 4 дүгээр улиралд 73.8 сая ам.доллар, 2022 оны 1-3 дугаар улирлын байдлаар нийт 52.5 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэсэн. Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.1-д гэрээлэгч нь жилийн эцсийн тайлангаа дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлдэг тул дүнг урьдчилан гаргах боломжгүй болно.<br>Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төвлөрүүлдэг төлбөр, урамшууллыг тооцож, нэхэмжлэн ажилласан бөгөөд 2022.11.20-ны өдрийн байдлаар гэрээлэгч компаниудад нийт 18 албан бичгийг хүргүүлсэн. Тусгай зөвшөөрлийн төлбөрт 1.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2.1 тэрбум төгрөг буюу 743.6 мянган ам.доллар, сургалтын урамшуулалд 1.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1.7 тэрбум төгрөг буюу 560.5 мянган ам.доллар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг (ТГҮАДТ)-ийн төлбөрт 1.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1.9 тэрбум төгрөг буюу 657.8 мянган ам.долларыг тус тус төвлөрүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ын дагуу гэрээлэгч компаниудын 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 10 дугаар сард төлсөн нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 20 хувийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг сум, дүүргийн төсөвт хуваарилах тооцоог аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр хийж, дүн мэдээг орлого орсон сар бүр Сангийн яаманд 4/42, 4/759, 4/1345, 4/3049, 5/4502, 2/5011, 2/5459 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 10 дугаар сард нөөц ашигласны төлбөр нийт 15.0 тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 10.5 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 4.5 тэрбум төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөр нийт 2.04 тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 1.4 тэрбум төгрөг, 8 аймгийн төсөвт 408.3 сая төгрөг, 81 (давхардсан тоогоор) сумын төсөвт 204.1 сая төгрөг тус тус хуваарилагдсан. | |
| **Зорилго 4. Хувийн хөрөнгөөр гүйцэтгэж буй ашигт малтмалын хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөөг хүлээн авах, хайгуулын ажлын зардлыг хянан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд ажлыг газар дээр нь шалгах, ашигт малтмалын нөөцийг өсгөнө.** | | | | | | | |
| 4.1 | Ашигт малтмалын хайгуулын ажлын үр өгөөжийг дээшлүүлж, эрдэс | - | Үнэн зөв хийгдсэн байна. | - | Ирүүлсэн тайлан, төлөвлөгөө, Эрдэс баялгийн | Хайгуулын ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, эрдэс баялгийн нөөцийг өсгөх ажлын хүрээнд эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 132 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хянаж, тухайн чиглэлээр ашигт малтмалын 6 төрлүүдээр бүртгэж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баялгийн нөөцийг өсгөнө. | | | | мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хүлээн авсан тайлангийн тоо хэмжээгээр | эрдэс баялгийн нөөцийг 132 тайлангаар өсгөх, Үндэсний геологийн албаны ГБТА-д холбогдох тушаал, дүгнэлтийг хүлээгэн өгсөн. Мөн нөөцтэй холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж, Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэст 10 удаа илгээсэн. | |
| 4.1.1 | Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн шаардлага хангасан ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөцийн тодотгол тайланг хүлээн авч хянах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх. Шийдвэрлэсэн тайлангаас нөөцийг ашигт малтмалын төрлөөр бүртгэн ажлын хэрэгцээний мэдээллийн санг хөтлөх, баяжуулах, нөөцтэй холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж өгөх | - | Тайланг хянах, хяналтын хуудсаар дүгнэх, санд бүртгэх ажлын хүрээнд ашигт малтмалын төрлөөр бүртгэнэ. | - | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хүлээн авсан 40 тайлангийн тоо хэмжээгээр хийгдсэн байна. | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр 132 хайгуулын ажлын үр дүн болон нөөцийн тодотгол тайланг хүлээн авч үүнээс хэлэлцсэн тайлан 128, компанийн хүсэлтээр хойшлогдсон 4.<br>Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар давхардсан тоогоор нийт 159-оос хүлээн авсан 92, дахин хэлэлцэхсэн 22.<br>Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдээс асууж, тодруулахад хариулт хангалтгүй шалтгаанаар буцаасан 35, хэлэлцээгүй нь компанийн захирал, шинжээч ирээгүй 10. Нөөцийн бүртгэлийг хөтөлж, ажлын хэрэгцээний санг үүсгэж,<br>нөөцтэй холбоотой мэдээ тайланг тухай бүр гаргасан. 132 аж ахуйн нэгжтэй утсаар, мэйлээр, цахимаар, биечлэн уулзаж, холбогдож ажилласан. Нийт 132 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох тушаалыг Үндэсний геологийн албаны даргаар нөөц хүлээж авсан шийдвэрийг гаргуулж, нөөцийг бүртгэсэн. Мөн тоогоор нөөцийг ашигт малтмалын голлох төрлүүдээр бүртгэж, ажлын хэрэгцээний мэдээллийн санг баяжуулж, нөөцтэй холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж, холбогдох газруудад гаргаж өгч ажилласан. | |
| 4.1.2 | Хувийн хөрөнгөөр гүйцэтгэх ашигт малтмалын хайгуулын ажлын жилийн тайланг цахимаар хүлээн авах, төлөвлөгөөг хянах, шаардлага хангасан төлөвлөгөөг хүлээн авах, мэдээллийн нэгдсэн санг нэмэлт мэдээллээр | - | Ирүүлсэн хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөөний й тоо хэмжээгээр | 2020, 2021 онд гүйцэтгэсэн ашигт малтмалын хайгуулын ажлын хянагдаж баталгаажсан тайлан, төлөвлөгөөг Геологийн баримтын төв | Ирүүлсэн хайгуулын ажлын 400 тайлан, хайгуулын ажлын 300 төлөвлөгөөг, хүчин төгөлдөр хайгуулын тусгай зөвшөөрлийн хэмжээнд холбогдох | 2022 оны ирүүлсэн нийт 1024 ажлын төлөвлөгөөг бүгдийг хянаж үүнээс: баталгаажсан 992, засварт буцаасан 31, татгалзсан 1 байна. 2021 оны илгээсэн нийт 907 ажлын тайланг бүгдийг хянаж үүнээс: баталгаажсан 780, засварт буцаасан 124, илгээсэн 2, татгалзсан 1 байна.<br>2020 онд ирүүлсэн ашиглалтын тайлан 74, ашиглалтын төлөвлөгөө 50, хайгуулын ажлын төлөвлөгөө 312, хайгуулын ажлын 374 тайланг цэгцлэж, Үндэсний геологийн албаны Геологийн баримтын төв архивд зохиох журмын дагуу бэлтгэж хүлээлгэн өгсөн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баяжуулж шинэчлэх, баталгаажсан тайлан, төлөвлөгөөг Геологийн баримтын төв архивд тушаах | | | архивд тушаасан. | архивд хүлээлгэн өгсөн байна. | | |
| 4.2 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | - | Чанартай үнэн зөв хийгдсэн байна. | - | Сонгон шалгаруулалтаар олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо хэмжээгээр | 2022 онд геологийн тогтоц, ашигт малтмалын мэдээллийг 156 талбайн хэмжээнд бэлтгэж үүнээс шинээр 90 хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үр дүнгээр олгогдсон нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн. | |
| 7.1.2 | Нөөцийн холбогдох мэдээллүүдээр сан үүсгэх, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнуудад ногдох нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн талбайд ногдох нөөцийг тооцох, талбайг хэсэгчлэн шилжүүлэх тохиолдолд нөөцийг талбай тус бүр ногдох байдлаар хувааж бүртгэж авах, тодорхойлолт гаргах | - | Холбогдох заавар, журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэсэн байна. | 2021 онд ашиглалтын үйл ажиллагааны 53 тайлан нөөцийн хэсэгт орж ирснээс шаардлага хангасан 47 тайлангийн нөөцийн хөдөлгөөнийг хийж санг баяжуулсан. | Ирүүлсэн хүсэлтийн тоогоор нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийсэн байна. | 2022 онд 2021 оны ашиглалтын үйл ажиллагааны 69 тайлан ирүүлснээс нөөцийн хэсгийн шаардлага хангасан 59 тайлангийн нөөцийн хөдөлгөөнийг хийж санг баяжуулсан.<br>Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн “Саруул сансар” ХХК-ийн NM-026048 дугаартай өргөдөл болон “Винтерблоссом” ХХК-ийн NM-025930 дугаартай өргөдлүүдийн талбайд ногдох нөөцийг бүртгэн авч лавлагааг Кадастрын хэлтэст гаргаж өгсөн | |
| **Зорилго 8. Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох кадастрын үйлчилгээ үзүүлнэ.** | | | | | | | |
| 8.1 | Геологи, уул уурхайн кадастрын бүртгэл хөтөлнө. | - | Холбогдох хууль, журам, зааврын дагуу хийсэн бүртгэлийн тоо | 2021 онд бүртгэлийг 100 хувь хийж гүйцэтгэсэн. | Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлийг Уул уурхайн кадастрын компьютержсэн системд бүрэн, үнэн зөв бүртгэсэн байна. | Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 296 дугаарт тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох уул уурхайн кадастрын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажилласан болно. Үүнд:<br>• Тусгай зөвшөөрлийн талбай буцаах, шилжүүлэх, барьцаалах, хугацаа сунгах, шинээр ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн, түгээмэл тархацтай ашигт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн нийт 712 өргөдөлд зураг зүйн шүүлт хийж, шүүлтийн хуудас хавсарган дотоод хяналтын хуудаст тэмдэглэгээ хийсэн.<br>• Мэргэжлийн хяналтын ерөнхий газраар батлуулсан Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 37 талбайн хилийн шав тэмдгийн тайланг хянан бүртгэв.<br>• Аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 23 тогтоол бүхий 63 газрын 531.8 мянган га талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т зааснаар Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв.<br>• Аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тусгай хэрэгцээнд авсан 12 тогтоол /43 газар бүхий 206.8 мянган талбайг/-ын хугацаа дууссаныг Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв.<br>• Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 189 албан бичгийг шүүж 57 тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн, захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлснийг тусгай зөвшөөрлийн хязгаарлалтын бүртгэлд бүртгэв.<br>Эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн албан бичгээр 32 тусгай зөвшөөрлийн захиран зарцуулах эрх, шилжилт хөдөлгөөн хийх эрхийг сэргээснийг Уул уурхайн кадастрын тусгай зөвшөөрлийн хязгаарлалтын бүртгэлд тус тус бүртгэж хариу мэдэгдэв.<br>Тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй аж ахуйн нэгшийн нэрээр тусгай зөвшөөрөл эзэмшдэг эсэх талаар лавлагаа авсан 100 бичигт хариу өгч ажилласан.<br>• Кадастрын хэлтсийн даргын 2022.01.01-нээс 2022.11.21-ний өдрийг хүртэлх хугацаанд гарсан нийт 428 шийдвэрт дугаар олгож Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн.<br>• 2022.01.01-нээс 2022.11.20-ны өдөр хүртэлх хугацаанд Хуулийн этгээдийн “К-4 маягт тодорхойлолтын дагуу давхардсан тоогоор нийт 608 хуулийн этгээдийн мэдээллийг шинэчлэн Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэж мэдээллийн зөрүүг арилгасан.<br>• Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх төрийн үйлчилгээг цахимжуулсан мэдээллийн системийг хөгжүүлсэн.<br>• Тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн материалуудыг сканердаж цахим хэлбэрт оруулах ажил хийгдэж байна. Дээрх ажлын хүрээнд тусгай зөвшөөрлийн хувийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэргийн архивд хадгалж байгаа хүчингүй болсон тусгай зөвшөөрлийн хувийн хэргээс 20 хувийг болон хүчинтэй бүх тусгай зөвшөөрөл, нийт 4351 тусгай зөвшөөрлийн 680,008 хуудас материалыг сканердан цахим хэлбэрт оруулсан.<br>• 2022 онд нийт 1344 тусгай зөвшөөрлийн цахим хэлбэрт шилжүүлсэн материалуудыг Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд тусгай зөвшөөрлийн хөдөлгөөн тус бүрээр бүртгэсэн.<br>• Шинээр олгогдсон 80 тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг үүсгэж архивын нэгж болгов. Эрх бүхий байгууллагуудад нотлох баримтын зориулалтаар хуулбарласан 3700 хуудас баримт бичигт хуулбар үнэн дардас дарж, баталгаажуулав.<br>• Сонирхсон этгээдэд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэл болон тэдгээрийн зураг зүйн бүртгэлийн талаарх 457 мэдээлэл, лавлагаа гаргаж өгсөн.<br>• Говь-Алтай, Төв, Өмнөговь, Баянхонгор, Дундговь, Увс, Хэнтий аймгуудаас бичил уурхайн дүгнэлт гаргуулах ирүүлсэн албан бичгүүдийн дагуу 27 талбайд дотоод хяналтын хуудас нээн, холбогдох хэлтэс, мэргэжилтнүүдээр хянуулан, боломжтой 1, боломжгүй 26 талбайн дүгнэлтийг аймгийн Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлсэн.<br>• 2022.11.20-ны өдрийн байдлаар 489 түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авсан байна. Нийт 306 өргөдөлд дүгнэлт гарган аймаг орон нутаг руу хүргүүлсэн. Үүнээс 151 өргөдөлд олгох боломжтой, 155 өргөдөлд боломжгүй дүгнэлт хүргүүлсэн. 183 өргөдөл хэлэлцэх шатанд байна. Өмнөх 2021 оны 69 өргөдлийг шийдвэрлэснээс, 40 өргөдөлд олгох боломжтой, 29 өргөдөлд олгох боломжгүй дүгнэлт хүргүүлсэн. 2020 оны шийдвэрлэгдээгүй он дамнасан 37 өргөдлийг татгалзаж шийдвэрлэсэн.<br>• Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| 8.1.1 | Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн бүх хөдөлгөөний өргөдлийн талбайд | - | Хуульд нийцүүлэн хийсэн зураг зүйн шүүлтийн тоо | 2021 онд 157 өргөдлийн талбайд зураг зүйн шүүлт хийсэн. | Тусгай зөвшөөрлийн бүх хөдөлгөөний өргөдлийн талбайд 200-аас багагүй | Тусгай зөвшөөрлийн талбай буцаах, шилжүүлэх, барьцаалах, хугацаа сунгах, шинээр ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн нийт 712 өргөдөлд зураг зүйн шүүлт хийж, шүүлтийн хуудас хавсарган дотоод хяналтын хуудаст тэмдэглэгээ хийж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зураг зүйн шүүлт хийх, зураг зүйн бүртгэлд хяналт тавих | | | | өргөдлийн зураг зүйн шүүлт хийсэн байна. | | |
| 8.1.2 | Тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авсан газар, Монгол улсын Засгийн газрын нөөц газар болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглосон, хязгаарласан талбайн бүртгэл хөтлөх | - | Хуульд нийцсэн тогтоол, шийдвэрийг бүртгэсэн тоо | 2021 онд 119 талбайн 3.2 сая гектар газрын тусгай хэрэгцээнд бүртгэсэн. | Ирүүлсэн тогтоол, шийдвэрийн тоогоор хуульд нийцүүлэн бүртгэсэн байна. | Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Өвөрхангай, Дорноговь, Дундговь, Төв, Ховд, Хөвсгөл аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 23 тогтоол бүхий 63 газрын 531.8 мянган га талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т зааснаар Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанаас 2022.02.09-ний өдрийн 33 дугаар “Отрын бүс бэлчээр газрыг бүртгүүлэх тухай” албан бичгээр ирүүлсэн Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан сумын Хэрлэнбаян-Улаан нэртэй газар, Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Увс аймгийн Ховд сумын Ачит нуур нэртэй газруудыг тус тус Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн тухай албан тоотыг 2022.03.03-ны өдрийн 8/1230 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>Булган, Дархан-Уул, Дорноговь, Дархан-Уул, Дорнод, Завхан, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь аймгуудын тусгай хэрэгцээнд авсан 12 тогтоол /43 газар бүхий 206.8 мянган талбайг/-ын хугацаа дууссаныг Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн. | |
| 8.1.3 | Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх төрийн үйлчилгээг бүрэн цахимжуулсан мэдээллийн системийг хөгжүүлэх | - | Төрийн үйлчилгээг цахимжуулсан системийг ашиглаж эхлэнэ. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд санал, төлөвлөгөө хүргүүлсэн. | Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн ашиглалтад оруулсан байна. | УУХҮ-ийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021.10.27-ны өдрийн А/273 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт холбогдох мэргэжилтнүүд ажиллаж ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг цахимжуулахаар Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран www.tender.gov.mn цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийлгүүлж бэлтгэл ажлыг хангав. Улмаар 2022.11.23-ны өдрөөс эхлэн 7 хоног бүр 25 талбайг олон нийтэд зарлан ажиллаж байна. Мөн цахим платформын танилцуулах сургалтыг 2022.04.15-ны өдөр танхимаар, 2022.04.21; 2022.05.04-ний өдрүүдэд цахимаар аж ахуйн нэгж болон сонирхсон этгээдүүдэд сургалт зохион байгуулж, гарын авлага, танилцуулга видео хичээлийг боловсруулан давхардсан тоогоор 500 гаруй хэрэглэгчдийг хамруулан зохион байгуулав. УУХҮ-ийн сайдын 2022.11.10-ны өдрийн А/282 тоот тушаалаар сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гишүүдийн цахим системд нэвтрэх тоон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарын үсгийг шинэчлэн авч сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажил хангасан.<br>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай мэдээлэл солилцох 2021 оны 2021/80 дугаартай гэрээний дагуу Уул уурхайн кадастрын бүртгэлийн системийн сантай холбох сервисийг үүсгэсэн бөгөөд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас гаргах сервис хүлээгдэж байна. Германы хамтын ажиллагааны BGR төслийн хүрээнд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас гаргах сервисийг холбох ажлыг төслийн ажлын даалгаварт тусгуулж шинэ хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн болно. | |
| 8.1.4 | Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн цахим архив үүсгэх | БГР төслийн сан хүү жил т | Цахим хэлбэрт шилжүүлсэн хувийн хэргийн тоо | 2021 онд хүчинтэй 2636, хүчингүй 551, нийт 3187 тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлсэн. | 800.000 гаруй хуудас хасагдсан өргөдөл, дуусгавар болсон, хүчингүй болсон, буцаан өгсөн, цуцлагдсан тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | Тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн цахим архив үүсгэх ажлын хүрээнд хүчин төгөлдөр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргээс гадна архивд хадгалагдаж буй хүчингүй болсон, дуусгавар болсон, цуцлагдсан, талбайгаа бүхэлд нь буцааж өгсөн тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн материалуудыг сканердаж цахим хэлбэрт оруулах ажил хийгдэж байна. Дээрх ажлын хүрээнд нийт **4351** тусгай зөвшөөрлийн 680,008 хуудас материалыг сканердан цахим хэлбэрт оруулсан.<br>АМГТГ-ын даргын 2022.02.15-ны өдрийн Д/01 дугаар “Тусгай зөвшөөрлийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх тухай” албан даалгаврын хүрээнд 2022 онд нийт 4200 тусгай зөвшөөрлийн цахим хэлбэрт шилжүүлсэн материалуудыг Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд тусгай зөвшөөрлийн хөдөлгөөн тус бүрээр бүртгэхээс 1344 тусгай зөвшөөрлийн хөдөлгөөнийг Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн бөгөөд Ашигт малтмал газрын даргын 2022.11.28-ны Д/06 дугаар албан даалгаврын дагуу тус ажлын хугацааг 2023.05.31-ний өдөр хүртэл сунгасан болно. | |
| 8.1.5 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл хүсэж орон нутагт гаргасан өргөдлийн дагуу шүүлт хийж, холбогдох дүгнэлт гаргах, хүргүүлэх | - | Хуульд нийцүүлэн шийдвэрлэсэн өргөдлийн тоо | 151 талбайд тусгай зөвшөөрөл олгох боломжтой, 49 талбайд олгох боломжгүй дүгнэлтийг холбогдох аймгийн Засаг даргад хүргүүлсэн. | Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хуулийн хүрээнд хянан шийдвэрлэсэн байна. | 2022.11.20-ны өдрийн байдлаар 489 түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авсан байна. Нийт 306 өргөдөлд дүгнэлт гарган аймаг орон нутагт хүргүүлсэн. Үүний 151 өргөдөлд олгох боломжтой, 155 өргөдөлд боломжгүй дүгнэлт хүргүүлсэн.<br>183 өргөдөл хэлэлцэх шатанд хянагдаж байна. Өмнөх 2021 оны 69 өргөдлийг шийдвэрлэснээс, 40 өргөдөлд олгох боломжтой, 29 өргөдөлд олгох боломжгүй дүгнэлт хүргүүлсэн. 2020 оны шийдвэрлэгдээгүй он дамнасан 37 өргөдлийг татгалзаж шийдвэрлэсэн.<br>Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар орох түгээмэл тархацтай ашигт малтмалын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хайгуулын тусгай зөвшөөрлийн нөөцийн 15 тойрох хуудаст хориглосон хязгаарласан талбайн шүүлт хийсэн.<br>2022.11.20-ны өдрийн байдлаар аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын 480 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр бүртгэлтэй байгаагаас ашиглалтын тусгай зөвшөөрөл 105, хайгуулын тусгай зөвшөөрөл 375 байна. | | |
| 8.2 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой өргөдлийн үйлчилгээ үзүүлнэ. | - | Холбогдох хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн өргөдлийн тоо | 2021 онд тусгай зөвшөөрөлтэй холбоотой өргөдлийг 100 хувь шийдвэрлэсэн. | Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний өргөдлийг хуулийн хүрээнд хянан шийдвэрлэсэн байна. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой өргөдлийн үйлчилгээг бүрэн үзүүлж ажилласан. Үүнд:<br>• Тайлангийн хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь буцаах 6, хэсэгчлэн буцаах 25 хүсэлт ирүүлснийг хүлээн авч бүртгэн, хянан шийдвэрлэж Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв.<br>• 2022 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах 219 өргөдөл ирүүлснийг хүлээн авч Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн. Үүнээс өмнөх оны эцэслэн шийдвэрлээгүй 89 өргөдлүүд нэмэгдэн хайгуулын 288 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 10 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзаж шийдвэрлэн Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв. Шийдвэрлэгдэх шатандаа хянагдаж байгаа 4, шүүхийн маргаантай 6 өргөдөл бүртгэлтэй байна. Шийдвэрлэгдсэн тусгай зөвшөөрлүүдийн холбогдох бичилтийг хийн эзэмшигчид гардуулан өгч, өргөдлийн хувийн хэргийг скайнердан цахим болгож бүртгэлийн системд холбон, цаасан хувийн хэргийг цэгцлэн хэлтсийн тусгай зөвшөөрлийн архивт хүлээлгэн өгсөн.<br>• Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк болон банк санхүүгийн байгууллагад барьцаалсныг бүртгүүлэхээр гаргасан 19 өргөдлийг хүлээн авч хянан үзээд барьцаанд бүртгэж шийдвэрлэн, холбогдох бичилтийг хийн, тусгай зөвшөөрөл, хавсралтыг барьцаалагчид хүлээлгэн өгсөн.<br>Тусгай зөвшөөрлийг барьцаанаас чөлөөлөх 22 хүсэлт ирүүлснийг хүлээн авч он дамжсан 2 тусгай зөвшөөрөл нэмэгдэн нийт 24 өргөдлийг хянан үзээд тусгай зөвшөөрлийг барьцаанаас чөлөөлж Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэн, тусгай зөвшөөрөл, хавсралтыг эзэмшигчид хүлээлгэн өгсөн.<br>Тусгай зөвшөөрлийг барьцаалсан бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах болон давхар барьцааг бүртгүүлэхийг хүссэн 25 өргөдлийг хянан үзээд, өөрчлөлтийг бүртгэж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэн, бичилтийг хийж барьцаалагчид хүлээлгэн өгсөн. Шийдвэрлэгдсэн өргөдлүүдийн хувийн хэргийг цахим болгон бүртгэлийн системд холбон, цаасан хувийн хэргийг цэгцлэн хэлтсийн тусгай зөвшөөрлийн архивд хүлээлгэн өгсөн.<br>• Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлэх 61 хүсэлт ирүүлснээс 55 тусгай зөвшөөрлийг бүхэлд нь, 6 тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсгийг шилжүүлснийг хянан шийдвэрлэж, Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн.<br>• Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтыг нөхөн авахыг хүссэн 11 өргөдөл ирүүлснийг бүртгэж, хянан үзээд 4 тусгай зөвшөөрлийг нөхөн олгохоос татгалзаж, 6 тусгай зөвшөөрлийг нөхөн олгохоор шийдвэрлэсэн. Хэлэлцэгдэх шатанд 1 өргөдөл хянагдаж байна.<br>• “Эрдмин” ХХК-ийн зүгээс гаргасан Эрдэнэт үйлдвэрийн MV-000011 дугаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг тусгай зөвшөөрлийн өргөдлийг 2021 оны 06 дугаарсарын 24-ний өдөр Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд UA-000002 дугаарт бүртгэсэн. Эрдмин ХХК-ийн зүгээс үүсмэл ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар нөөцийн тодотгол хийлгэх шаардлагыг холбогдох нэгжүүдээс тавьсан тул өргөдөл хянан шийдвэрлэх ажиллагаа түр зогсож хүлээгдэж байна. Тус хэлтсээс шалтгаалаагүй болно.<br>• Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь заалтад заасан үндэслэлээр ашигт малтмалын ашиглалтын 23, хайгуулын 24, нийт 47 тусгай зөвшөөрлийг цуцалсан.<br>• Ашигт малтмалын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1 дэх заалтад заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан ашигт малтмалын хайгуулын 97 тусгай зөвшөөрлийг дуусгавар болсныг Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв.<br>• Цөмийн энергийн тухай хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн 1 өргөдөл, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 13 тусгай зөвшөөрлийн эрхийг сэргээн бүртгэхийг даалгасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хийгдэж байна. Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт зааснаар цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохдоо хуульд заасан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрийн захиргааны байгууллагаас санал авч мөн зүйлийн 18.9 дэх хэсэгт зааснаар тусгай зөвшөөрлийн баримт бичгийг хянан шийдвэрлэх хугацаа 12 сар хүртэл байдаг болно.<br>• Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл болон түүний шилжилт хөдөлгөөн, шинээр олгосон тусгай зөвшөөрөл, хүлээн авсан өргөдлийн 2022 оны 1-11 дүгээр сарын нийт 11 статистик мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэн, Татварын ерөнхий газарт хүргүүлэв.<br>• 2022 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах 219 өргөдөл ирүүлснийг хүлээн авч Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн. Үүнээс өмнөх оны эцэслэн шийдвэрлээгүй 89 өргөдлүүд нэмэгдэн хайгуулын 288 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 10 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзаж шийдвэрлэн Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв. Шийдвэрлэгдэх шатандаа хянагдаж байгаа 4, шүүхийн маргаантай 6 өргөдөл бүртгэлтэй байна. Шийдвэрлэгдсэн тусгай зөвшөөрлүүдийн холбогдох бичилтийг хийн эзэмшигчид гардуулан өгч, өргөдлийн хувийн хэргийг скайнердан цахим болгож бүртгэлийн системд холбон, цаасан хувийн хэргийг цэгцлэн хэлтсийн тусгай зөвшөөрлийн архивт хүлээлгэн өгсөн.<br>• 2020, 2021 онуудад он дамжсан 55 өргөдөл, 2022 онд 28 өргөдөл, нийт 83 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл бүртгэлтэй байснаас шинээр 32 ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон. 18 өргөдлийг татгалзан шийдвэрлэсэн байна. Ашигт малтмалын хуулиар олгосон 2 түгээмэл тархацтай өргөдлийг орон нутагт нь шилжүүлсэн. Хэлэлцэх шатанд 31 өргөдөл хянагдаж байна.<br>• Ашигт малтмалын 2260 тусгай зөвшөөрлийн төлбөр бүртгэн, хавсралтад тэмдэглэгээ хийв. | |
| 8.2.1 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгох ажлыг зохион байгуулах | - | Холбогдох хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэж олгосон тусгай зөвшөөрлийн тоо | 2021 онд хайгуулын 109, ашиглалтын 53 тусгай зөвшөөрлийг шинээр олгож бүртгэсэн. | Ашигт малтмалын 100-аас багагүй тусгай зөвшөөрөл олгож, өргөдлийг хуулийн хүрээнд хянан шийдвэрлэсэн байна. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгох ажлыг зохион байгуулж ажиллав. Үүнд:<br>• Монгол Улсын Засгийн газрын 2018.08.08-ны өдрийн “Талбайн солбицлыг тогтоох тухай” 243 дугаар тогтоолын солбицолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай албан хүсэлтийг УУХҮЯ-нд АМГТГ-ын даргын 2022.03.17-ны өдрийн 1/1473 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>• 2022 оны 01 дүгээр сараас эхлэн нийт 2 багцаар СШ-62, СШ-63 дугаартай сонгон шалгаруулалтын 30 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарлав. УУХҮ-ийн сайдын 2022.05.23-ны өдрийн 01/1488 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой 2.3 сая гектар талбайг Уул уурхайн кадастрын зураг зүйн бүртгэлд бүртгэсэн.<br>• 2022.01.03-ны өдрөөс 2022.02.15-ны өдрийн хооронд СШ-59, СШ-60, СШ-61, СШ-62, СШ-63 дугаартай сонгон шалгаруулалтын талбайн 128 багц мэдээллийг аж ахуйн нэгжүүдэд өгч, сонгон шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн 119 саналын материалыг хүлээн авч бүртгэв.<br>• 2022.01.05-ны өдрийн Газрын даргын А/01, А/02 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор зарласан нийт 2 багцаар СШ-62, СШ-63 дугаартай сонгон шалгаруулалтын 30 талбайн 142,002.97 га талбайг уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэж үүнээс санал ирүүлээгүй 15 талбайг бүртгэлээс хасав.<br>• 2022.01.01-ний өдрөөс 2022.04.06-ны өдрийн хооронд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад шалгарсан 50 талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсралтын хамт бичиж олгов.<br>• Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу 7 талбайд Кадастрын хэлтсийн даргын шийдвэрийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтыг бичиж олгов.<br>• 2020, 2021 онуудад он дамжсан 55 өргөдөл, 2022 онд 28 өргөдөл, нийт 83 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл бүртгэлтэй байснаас шинээр 32 ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон. 18 өргөдлийг татгалзан шийдвэрлэсэн байна. Ашигт малтмалын хуулиар олгосон 2 түгээмэл тархацтай өргөдлийг орон нутагт нь шилжүүлсэн. Хэлэлцэх шатанд 31 өргөдөл хянагдаж байна. | |
| 8.2.2 | Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах өргөдлийг хянан шийдвэрлэх | - | Хуульд нийцүүлэн шийдвэрлэсэн өргөдлийн тоо | 2021 онд хугацааг сунгах 244 өргөдлийг хянан шийдвэрлэсэн. | Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах 100-аас багагүй өргөдлийг хянан шийдвэрлэсэн байна. | 2022 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах 219 өргөдөл ирүүлснийг хүлээн авч Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн. Үүнээс өмнөх оны эцэслэн шийдвэрлээгүй 89 өргөдлүүд нэмэгдэн хайгуулын 288 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 10 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзаж шийдвэрлэн Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв. Шийдвэрлэгдэх шатандаа хянагдаж байгаа 4, шүүхийн маргаантай 6 өргөдөл бүртгэлтэй байна. Шийдвэрлэгдсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгай зөвшөөрлүүдийн холбогдох бичилтийг хийн эзэмшигчид гардуулан өгч, өргөдлийн хувийн хэргийг скайнердан цахим болгож бүртгэлийн системд холбон, цаасан хувийн хэргийг цэгцлэн хэлтсийн тусгай зөвшөөрлийн архивт хүлээлгэн өгсөн. | |
| 8.2.3 | Тусгай зөвшөөрөл барьцаалах, барьцаанаас чөлөөлөх өргөдлийг хянан шийдвэрлэх | - | Хуульд нийцүүлэн шийдвэрлэсэн өргөдлийн тоо | 2021 онд тусгай зөвшөөрлийн барьцаалсныг бүртгэх 37, барьцаанаас чөлөөлөх 18 өргөдлийг хянан шийдвэрлэсэн. | Тусгай зөвшөөрлийн барьцаалсныг бүртгэх, барьцаанаас чөлөөлөх өргөдлийг хуулийн хүрээнд хянан шийдвэрлэсэн байна. | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк болон банк санхүүгийн байгууллагад барьцаалсныг бүртгүүлэхээр гаргасан 19 өргөдлийг хүлээн авч хянан үзээд барьцаанд бүртгэж шийдвэрлэн, холбогдох бичилтийг хийн, тусгай зөвшөөрөл, хавсралтыг барьцаалагчид хүлээлгэн өгсөн.<br>Тусгай зөвшөөрлийг барьцаанаас чөлөөлөх 22 хүсэлт ирүүлснийг хүлээн авч он дамжсан 2 тусгай зөвшөөрөл нэмэгдэн нийт 24 өргөдлийг хянан үзээд тусгай зөвшөөрлийг барьцаанаас чөлөөлж Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэн, тусгай зөвшөөрөл, хавсралтыг эзэмшигчид хүлээлгэн өгсөн.<br>Тусгай зөвшөөрлийг барьцаалсан бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах болон давхар барьцааг бүртгүүлэхийг хүссэн 25 өргөдлийг хянан үзээд, өөрчлөлтийг бүртгэж шийдвэрлэн, бичилтийг хийж барьцаалагчид хүлээлгэн өгсөн. Шийдвэрлэгдсэн өргөдлүүдийн хувийн хэргийг цахим болгон бүртгэлийн системд холбон, цаасан хувийн хэргийг цэгцлэн хэлтсийн тусгай зөвшөөрлийн архивд хүлээлгэн өгсөн. | |
| 8.2.4 | Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг буцаан өгөх өргөдлийг хянан шийдвэрлэх | - | Хуульд нийцүүлэн шийдвэрлэсэн өргөдлийн тоо | 2021 онд тодорхой хэсгийг болон бүхэлд нь буцаасныг бүртгүүлэх 22 өргөдлийг шийдвэрлэсэн. | Тусгай зөвшөөрлийн талбайгаас хэсэгчлэн болон бүхэлд нь буцаах өргөдлийг хуулийн хүрээнд хянан шийдвэрлэсэн байна. | Тайлангийн хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь буцаах 6, хэсэгчлэн буцаах 25 хүсэлт ирүүлснийг хүлээн авч бүртгэн, хянан шийдвэрлэж Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэв. Холбогдох бичилтийг хийн тусгай зөвшөөрлийг эзэмшигчид гардуулан өгч, хувийн хэргийг цэгцлэн Кадастрын хэлтсийн тусгай зөвшөөрлийн архивд тухай бүр хүлээлгэн өгсөн.<br>MV-017189 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас хэсэгчлэн буцаан өгөхийг хүссэн өргөдлийг Кадастрын хэлтсийн даргын 2022.08.10-ны өдрийн 01 шийдвэрээр, XV-018797, XV-020539 дугаар тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь буцаан өгөхийг хүссэн өргөдлийг Кадастрын хэлтсийн даргын 2022.09.05-ны өдрийн 19 дүгээр шийдвэрээр тус тус татгалзаж шийдвэрлэсэн. | |
| **Зорилго 9. Байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт, чиг, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулахад эрх зүйн дэмжлэг, хууль зүйн туслалцаа үзүүлнэ.** | | | | | | | |
| 9.1 | Салбарын чиглэлээр | - | Хууль, заавар, | Хууль тогтоомжийн 7 | Хуулийн шаардлага | Тайлант хугацаанд: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдөгдөж буй хууль бусад хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, төслийн хувилбар боловсруулна. | | журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэсэн байна. | төсөлд санал өгч ажилласан. | хангаж 100% хийгдсэн байна. | • Тайлант хугацаанд дээд шатны байгууллагаас ирүүлсэн нийт 7 хуулийн төсөлд санал өгч холбогдох төрийн захиргааны төв байгууллагад 7 албан бичгээр, УУХҮЯ-наас ирүүлсэн 18 албан бичигт судалж хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br>• Агентлагийн даргын тушаалаар нийт 2 зааварт санал өгч, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн төслийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэн батлуулсан.<br>• Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮ-ийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Уг ажлын хэсэгт манай байгууллагаас агентлагийн дарга болон Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Хайгуулын ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн дарга, Кадастрын хэлтсийн дарга нар ажиллаж байна. | |
| 9.1.1 | УИХ, Монгол улсын Засгийн газраас салбарын чиглэлээр батлан гаргах тогтоол шийдвэрийн төсөлд санал өгч ажиллах | - | Санал өгсөн хуулийн тоо | 5 | Санал авахаар ирүүлсэн салбарын холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төслийн өөрт хуваарилагдсан тоогоор | Тайлант хугацаанд:<br>• Дээд шатны байгууллагаас ирүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Газрын багц хуулийн төсөл, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл, “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл”-д тус тус санал өгч холбогдох төрийн захиргааны төв байгууллагад 7 албан бичгээр;<br>• УУХҮЯ-наас 18 албан бичиг ирүүлснийг судлан үзэж холбогдох нэгж хэлтсээс шаардлагатай баримт материалыг бүрдүүлж хариу бичгийн төслийг боловсруулж батлуулан 18 албан бичгээр;<br>• Иргэд, аж ахуйн нэгжээс 711 албан бичиг, 92 өргөдөл гомдол ирүүлснээс хариутай 510 албан бичгийн 501-т хариуг өгч шийдвэрлэлт 98.2 хувьтай байна. Өргөдөл гомдлын 92 гомдолд үндэслэл бүхий хариуг боловсруулан удирдлагаар батлуулж хуулийн хугацаанд хүргүүлсэн. Шийдвэрлэлт 100 хувьтай байна. 9 албан бичгийн хариу, боловсруулагдаж батлагдах шатанд байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9.1.2 | Ашигт малтмалын салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, аргачилсан зөвлөмжийг боловсруулахад оролцох | - | Санал өгсөн хуулийн тоо | 1 | 1 | Агентлагийн даргын тушаалаар нийт 2 зааварт санал өгч, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн төслийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэн батлуулсан. Үүнд:<br>• АМГТГ-ын даргын 2022.05.02-ны өдрийн А/52 дугаар тушаалаар “Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн болон тодотгол тайланг хянахад баримтлах дотоод заавар”-ыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Заавар батлагдахаас өмнө 8 албан тушаалтан танилцдаг байсан 5 болж цөөрсөн бөгөөд нэг албан тушаалтан ажлын 2 өдөр танилцахаар өөрчлөлтийг оруулсан.<br>• Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг цахимаар ирүүлэхтэй холбоотойгоор АМГТГ-аас нийтээр даган мөрдөх /хэм хэмжээний акт/ зааврын төслийг тус газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс эцэслэн найруулж, “Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх, хүлээн авах заавар”-ын төслийг боловсруулан агентлагийн даргын 2022.10.18-ны өдрийн А/121 дүгээр тушаалаар батлуулсан. Улмаар ХЗДХЯ-нд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, 2022.10.24-ний өдрийн 1/5191 дүгээр албан бичгээр тус яаманд хүргүүлсэн. ХЗДХЯ манай байгууллагаас хүргүүлсэн баримт бичгийг судлаад “Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх, хүлээн авах заавар”-ыг баталсан 2022.10.18-ны өдрийн А/121 дүгээр тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5985 дугаарт бүртгэсэн болохыг манай байгууллагад 2022.10.27-ны өдрийн 1/5430 дугаар албан бичгээр мэдэгдсэн. | |
| 9.1.3 | Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад оролцох | - | Санал өгсөн хуулийн тоо | 1 | 1 | УУХҮ-ийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралд 4 удаа хуралдаж ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан холбогдох санал дүгнэлтийг тухай бүр хүргүүлж ажилласан.<br>2022.05.11-ний өдрийн ажлын хэсгийн нарийн бичгээс ирүүлсэн төслийг дахин нягтлах байдлаар хянаж хариуг цахим шуудангаар хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Уул уурхайн салбарын мэргэжлийн холбоодод танилцуулж, санал авах ажлыг УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газартай хамтран 2022.05.20-ны өдөр зохион байгуулсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮ-ийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан.<br>Уг ажлын хэсэгт манай байгууллагаас агентлагийн дарга болон Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Хайгуулын ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн дарга, Кадастрын хэлтсийн дарга нар ажиллаж байна. | |
| 9.1.4 | Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 22 дугаар зүйл, 33 дугаар зүйл, 48 дугаар зүйл, 56 дугаар зүйлд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгж, олон нийтэд хууль, тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | - | Хууль, заавар, журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэсэн байна. | - | Хуулийн шаардлага хангаж 100% хийгдсэн байна. | "Монзол" ХХК-аас ирүүлсэн хүсэлтээр тойм судалгаа хийх мэдэгдлийг хүлээн авч хариуг албан бичгээр 2022.02.15-ны өдөр 13/835 дугаараар илгээсэн.<br>АМГТГ-ын удирдлага, нэгжүүдийн бүрэлдэхүүнтэй Монгол Улсын хэмжээнд "Шинэ сэргэлтийн бодлого", Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хүрээнд 2022.03.15-наас 2022.05.15-ны хооронд Улсын хэмжээнд 21 аймаг, 1 дүүрэгт Төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн удирдлагын байгууллага гэсэн гурвалсан уулзалтыг зохион байгуулж аж ахуйн нэгж, нутгийн удирдлагууд, төрийн байгууллагууд, ард иргэдийн эрх, үүргийн талаар танилцуулж, хууль, тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажилласан. | |
| 9.1.5 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгж, олон нийтэд хууль, тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | - | Хууль, заавар, журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэнэ. | - | Хуулийн шаардлага хангаж 100% хийгдсэн байна. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн нийт 301 өргөдлийн дотоод хяналтын хуудас хянасан.<br>АМГТГ-ын удирдлага, нэгжүүдийн бүрэлдэхүүнтэйгээр 2022.03.15-наас 2022.05.15-ны хооронд 21 аймагт албан томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, ард иргэдтэй уулзаж, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9.2 | Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг сунгах, шилжүүлэх, барьцаалах, талбай буцаан өгөх зэрэг тусгай зөвшөөрлийн хөдөлгөөнтэй холбоотой Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах, өргөдлийн материалд холбогдох хууль тогтоомж, зааврын дагуу эрх зүйн шүүлт хийнэ. | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | 441 өргөдөл, 149 хяналтын хуудсанд эрх зүйн шүүлт хийсэн. | Тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн шүүлтийг холбогдох хуульд нийцүүлж хянана. | Тайлант хугацаанд: Кадастрын хэлтсээс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн 487 өргөдөл, 525 дотоод хяналтын хуудсанд эрх зүйн шүүлт хийсэн. | |
| 9.2.1 | Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөнтэй холбоотой өргөдөлд эрх зүйн шүүлтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, үндэслэлтэй хийж, санал дүгнэлт өгөх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | 441 өргөдөл, 149 хяналтын хуудсанд эрх зүйн шүүлт хийсэн. | Геологи, уул уурхайн кадастрын хэлтсээс ирүүлсэн эрх зүйн шүүлтийн хуваарилагдсан тоогоор | Кадастрын хэлтсээс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн 487 өргөдөл, 525 хяналтын хуудсанд эрх зүйн шүүлт хийсэн. Үүнд:<br>• Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох 47;<br>• Тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлсэн 85;<br>• Талбайгаа хэсэгчлэн болон бүхэлд нь буцааж хүлээлгэн өгсөн 26;<br>• Барьцаалсан болон барьцаанаас чөлөөлсөн 61;<br>• Тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацааг сунгах 236;<br>• Тусгай зөвшөөрлийг нөхөн олгох, татгалзах 13;<br>• Тусгай зөвшөөрөл тусгай зөвшөөрөл цуцлах 404;<br>• Тусгай зөвшөөрөл тусгай зөвшөөрөл дуусгавар болгох 121;<br>• Өргөдлийн бүртгэлээс хасах 3;<br>• Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах 7;<br>• Тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацааг сунгахаас татгалзах 9. | |
| **Зорилго 10. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлнэ.** | | | | | | | |
| 10.1 | Газрын тос, уламжлалт бус | - | Газрын тосны тухай хууль | - | Газрын тос, уламжлалт бус | • УУХҮЯ-нд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах боломжтой гэрээлэгчгүй 10, Бүтээгдэхүүн хуваах гэрээ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх арга хэмжээ авсан байна. | | болон бусад хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцсэн байна. | | газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлсэн байна. | цуцлагдах нөхцөл бүрдсэн 8, нийт 18 талбайн мэдээллийг 2022.04.04-ний өдөр хүргүүлсэн.<br>• УУХҮЯ-наас 2022.09.14-ний өдрийн 01/2444 дугаар албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу 14 талбайн судалгааны багц материал бэлтгэсэн.<br>• УУХҮ-ийн сайдын 2022.11.29-ний өдрийн А/294 дугаар тушаалын дагуу газрын тосны хайгуулын 5 талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан.<br>• Эрлийн ажлын үр дүнгээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах 3 хүсэлт ирүүлсэн бөгөөд ажлын хэсгүүд ажиллаж байна.<br>• Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах 9 хүсэлт ирснээс “Жейд газ Монголиа” ХХК, “Баруун наран газ” ХХК, “Си Эйч Би Ти Ти” ХХК-уудтай эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.<br>• Хайгуулын гэрээт 13 талбайд 2022 онд хийж гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв ирүүлсэн. Үүнээс 12 талбайн төлөвлөгөө төсөв батлуулсан.<br>• Хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрлийн гэрээт 8 талбайгаас 5 талбайд 2022 оны эрлийн ажлын төлөвлөгөө төсөв ирүүлж батлуулсан.<br>• Эрлийн 5 талбайн 6 тайлан, хайгуулын 4 талбайн 27 тайлан нийт 31 тайлан хүлээн авч холбогдох мэргэжилтнүүд судлан 5 тайланг засварт буцаасан, 26 тайланг хүлээн авсан байна.<br>• “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын техникийн зөвлөл” нь АМГТГ-ын мэргэжлийн зөвлөл болон өөрчлөгдсөн бөгөөд 2022.06.23; 2022.08.19–ний өдрүүдэд хуралдаж, “Юу Жи Эс”, “Тэмүүжин металс” ХХК-уудын эрлийн ажлын үр дүнг хүлээн авсан.<br>• 2022 оны 11 дүгээр сарын байдлаар хэлтсийн 10 мэргэжилтэн давхардсан тоогоор нийт 149 хоног орон нутагт гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих ажлаар томилолтоор ажилласан байна.<br>• АМГТГ-ын даргын 2022.01.07-ны өдрийн А/06 тушаалаар батлагдсан ажлын хэсэг бүтээгдэхүүн хуваах гэрээт 13 талбай, эрлийн гэрээт 12 талбайд жилийн ажлын уулзалтыг цахим болон танхимын уулзалт хэлбэрээр 2022.01.12-ны өдрөөс 2022.03.07-ны өдрийн хооронд зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.1.1 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбайд сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг хангах, захиалга хүлээн авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, хайгуулын талбайд болон эрлээс хайгуулд шилжиж байгаа талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах | - | Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын шаардлагыг хангасан, мэдээлэл нотолгоонд суурилсан байна. | 2021 онд 1 бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. | Нээлттэй талбайн товч мэдээллийг бэлтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. Төрийн захиргааны төв байгууллагаас Газрын тосны тухай хуулийн 8.1.4-т заасны дагуу чиглэл ирүүлсэн талбайн багц материалыг бэлтгэнэ. | УУХҮЯ-наас 2022.02.24-ний өдрийн 08/470 дугаар албан бичгээр Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах боломжтой талбайн мэдээллийг талбай тус бүрээр бэлтгэх чиглэл өгсний дагуу АМГТГ-ын 2022.04.04-ний өдрийн 1/1990 дугаар албан бичгээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлах боломжтой гэрээлэгчгүй 10 (Шарга III, Нэмэгт VI, Хонгор VIII, Чойр XXV, Борзон VII, Төхөм X хойд, Цагаан Элс XIII, Зүүнбаян XIV, Буйр XXII, Цайдам XXVI), Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлагдах нөхцөл бүрдсэн 8 (Хар-Ус II, Богд IV, Номгон IX, Нялга XVI, Хөхнуур XVIII, Дарьганга XXIV, Сүхбаатар XXVII, Хэрлэнтохой XXVIII) талбайн танилцуулга, өртөг нөхөх зардал болон тайлангуудын жагсаалт зэргийг хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2022.09.05-ны өдрийн 337 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу АМГТГ-ын даргын 2022.09.28-ны өдрийн А/109 тушаалаар Хар-Ус II, Номгон IX, Дарьганга XXIV, Хэрлэнтохой XXVIII талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан.<br>УУХҮЯ-наас 2022.09.14-ний өдрийн 01/2444 дугаар албан бичгээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлахтай холбогдуулан 14 талбайн судалгааны багц материал бэлтгэх, үнэ тогтоох чиглэл өгсний дагуу 14 (Хар-Ус II, Шарга III, Нэмэгт VI, Борзон VII, Хонгор VIII, Номгон IX, Төхөм X хойд, Цагаан-Элс XIII, Зүүнбаян XIV, Баянхошуу XXII, Дарьганга XXIV, Чойр XXV, Цайдам XXVI, Хэрлэнтохой XXVIII) талбайн геологийн судалгааны багц материалыг бэлтгэж, тус талбайнууд хамарч байгаа 14 аймаг, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт 2022.09.22-ны өдрийн 1/4705-1/4719 дугаар дүгнэлт гаргуулах тухай албан бичгийг хүргүүлсэн, эдгээр талбайд 3 үе шаттайгаар сонгон шалгаруулалт зарлах төлөвлөгөө гаргасан тухайгаа УУХҮЯ-нд 2022.11.16-ны өдрийн 1/5588 дугаар албан бичгээр мэдээлж, чиглэл хүссэн УУХҮ-ийн сайдын 2022.11.29-ний өдрийн А/294 дугаар тушаал, УУХҮЯ-ны 2022.11.29-ний өдрийн 08/3151 дугаар албан бичгийн дагуу газрын тосны хайгуулын Номгон IX, Төхөм X хойд, Цагаан Элс XIII, Зүүнбаян XIV, Дарьганга XXIV талбайнуудад 2022.11.30-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. https://mrpam.gov.mn/news/2447/<br>Эрлийн ажлын үр дүнгээр "Юу Жи Эс" ХХК, "Тэмүүжин металс" ХХК-уудаас Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах 3 санал ирүүлсэн бөгөөд агентлагийн даргын 2022.08.19-ний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн А/93, 2022.09.02-ны өдрийн А/99, 2022.10.27-ны өдрийн А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдэд хэлтсийн мэргэжилтнүүд хуваарилагдан ажиллаж байна. | |
| 10.1.2 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил хийх хүсэлт хүлээн авч хянан санал дүгнэлт гаргах, холбогдох хууль дүрэм журмын шаардлага хангасан хуулийн этгээдтэй эрлийн гэрээ байгуулах | - | Газрын тосны тухай хуулийн 15, 16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан байна. | 2021 онд 10 эрлийн гэрээ байгуулах хүсэлтийн материалыг хүлээн авч хянан шаардлага хангасан 4 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан. | Эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлсэн материалыг хянан шаардлага хангасан хуулийн этгээдтэй эрлийн гэрээ байгуулна. Шаардлага хангасан хүсэлт ирүүлсэн тоо хэмжээгээр хязгаарлагдана. | • Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах 9 хүсэлтийг хүлээн авсан.<br>• "Жейд газ Монголиа" ХХК-аас 2021.12.21-ний өдөр нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч, холбогдох мэргэжилтнүүдийн гаргасан санал, дүгнэлтийг нэгтгэн Шивээговь талбайд 2022.01.27-ны өдөр нүүрсний давхаргын метан хийн эрлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.<br>• "Би Ти Ти Си Жи Жи" ХХК-аас 2022.01.31-ний өдөр газрын тосны эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч, холбогдох мэргэжилтнүүдийн гаргасан санал, дүгнэлтийг нэгтгэн удирдлагад танилцуулсан, удирдлагаас хөрөнгө оруулалт тодорхойгүй, ажлын туршлагагүй тул гэрээ байгуулах боломжгүй гэсэн шийдвэр гаргасан талаар компанид 2022.03.16-ны өдөр утсаар мэдэгдсэн.<br>• "Криптон ресурсес" ХХК-аас 2022.03.07-ны өдөр нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч, холбогдох мэргэжилтнүүдийн гаргасан санал, дүгнэлтийг нэгтгэн удирдлагад танилцуулсан, удирдлагаас хөрөнгө оруулалт тодорхойгүй, ажлын туршлагагүй тул гэрээ байгуулах боломжгүй гэсэн шийдвэр гаргасан талаар компанийн захирал М.Сугар /99091568/-т 2022.05.05-ны өдөр утсаар мэдэгдсэн.<br>• "Жи Өү Эйч" ХХК-аас 2022.03.07-ны өдөр нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч, эрлийн ажил хийх хүсэлтийн талбайн солбицлыг шалгаж үзэхэд улсын тусгай хамгаалалттай газартай 68,75 км2 талбай давхцаж байгааг мөн талбайн хэмжээ хэтэрсэн тухай 2022.03.23-ны өдрийн 2/1586 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>• "Жи Өү Эйч" ХХК-аас 2022.05.25-ны өдөр нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч, хайгуулын талбайтай давхцаж байгаа тухай 2022.06.29-ний өдрийн 1/3485 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>• "Жи Өү Эйч" ХХК-аас 2022.07.04-ний өдөр нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирүүлснийг хүлээн авч, талбайн хэмжээ хэтэрсэн тухай 2022.11.01-ний өдрийн 1/5348 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>• “Си Эйч Би Ти Ти” ХХК-аас 2022.05.04-ний өдөр газрын тосны эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч, холбогдох мэргэжилтнүүд санал, дүгнэлт гаргаж, 2022.07.29-ний өдөр газрын тосны Эрлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.<br>• “Баруун наран газ” ХХК-аас 2022.05.16-ны өдөр нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг хүлээн авч, холбогдох мэргэжилтнүүд санал, дүгнэлт гаргаж, 2022.07.22-ны өдөр нүүрсний давхаргын метан хийн Эрлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.<br>• “Ууган булаг” ХХК-ийн 2022.11.07-ны өдрийн 22/05 дугаар эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хүсэлтийг судалж, газрын тосны хайгуулын Баянхошуу XXII талбайтай хэсэгчлэн давхцалтай тул 2022.11.16-ны өдрийн 3/5572 дугаар албан бичгээр хүсэлтийг хانган шийдвэрлэх боломжгүйг мэдэгдсэн. | |
